

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭНЭТЭМБЕР УХЛААНЫ ФАКУЛЬТЕТ

ТҮҮЖ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ № 488 (14) 2002 он

RUSSIA



INDIA

Гарчиг

Эрхэм уншигч Танаа

5

Монголын түүх

1. П.Дэлгэржаргал. Мэнгу шивэй аймгийн угсаа гарлыг нэхэн сурвалжлах нь. 8
2. Д.Хүүхэнбаатар, П.Дэлгэржаргал. Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний түүхийн асуудал. (XX зууны эхний хагас). 12
3. Д.Энхцэцэг. Үндэсний эв нэгдэл- тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн баталгаа болох нь. 18
4. Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь гадаадынхны үйл ажиллагаа. 23
5. З.Лонжид. Дундат иргэн улсаас Монголын тухай баримталсан бодлогыг нэхэн судлахуй. (1919 оноос хойш) 29
6. С.Отгонжаргал. XX зуунд Монголд гарсан хөрөнгөлөг ардчилсан хувьсгалын асуудалд. 34
7. Н.Хишигт. Монголын түүхэнд Барон Унгерний холбогдох нь /1921-1925/ 42
8. Б.Пунсалдулам. Монгол дахь Буриадын хурал. 51

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

1. Б.Ралгаа. Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн нь. 57
2. С.Түвшин. Ж.Цэвээний улс төр, нийгэм-эдийн засгийн үзэл баримтлалын тухайд. 68
3. З.Баасанжав. МУИС байгуулагдсан түүхээс. 73
4. Л.Ариунаа. Монголд өөрөө удирдах ёсны түүхэн уламжлал байсан уу? (Бодрол, тэмдэглэл). 78

Байгаль хамгаалах түүхэн уламжлал

1. Ж.Болдбаатар, С.Дэмбэрэл. Монголчуудын байгаль орчноо хамгаалах зан заншил, хууль тогтоомжийн түүхэн тойм (Нэн эртнээс XX зуун). 80
2. Л.Чулуунбаатар. Ган зудын гамшиг, гэтлэн давах арга замын тухайд. 99

Гадаад харилцааны түүх

1. Ута Шёне. 1920-иод онд Герман улсад суралцаж байсан монгол сурагчдад болон Лайпцигт хэвлүүлсэн монголын газрын зургийн түүхэнд холбогдох зарим тэмдэглэл. 104
2. Р.Төрдалай. Франц улсын Парис хотын монгол сурагчид /Түүхэн тэмдэглэл/. 110

Түүх бичлэг

1. Удо Баркманн. Монголын түүхийн талаархи олон улсын судалгаа: Эзгүйрэл, улс төрийн ашиг хонжоо хоёрт идэгдсэн Монголын түүх. 114
2. Б.Пунсалдулам. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын тухай түүх бичлэгийн зарим асуудалд. 127

Түүхэн газар зүй

1. Д.Сүхбаатар. Монгол орны түүхэн газар усны нэрийн тухай. 133

Хавсралт

1. Түүхийн салбарыг төгссөн алдартнууд 137
2. Зохиогчдын товч танилцуулга 139

Монгол орны түүхэн газар усны нэрийн тухай

Доктор /Ph/ Д.Сүхбаатар /МУИС/

Түүхийн шинжлэх ухааны хөгжилд түүхийн салбар ухаанууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Он дарааллын түүхийн баримтад түшиглэн, салбар ухааны туслалцаатайгаар түүхэн бодит үнэнийг тогтоох шаардлага зүй ёсоор тавигдаж байдаг.

Түүхэн газар усны нэрийг тусгайлан судалдаг түүхийн салбар ухаан бол топонимик юм. Энэ нь топос- байр байршил, онома буюу нэр гэсэн эртний грек үгнээс гаралтай¹. Харин монгол хэлэнд энэхүү нэр томъёог түүхэн газар усны нэр судлал гэж буулгадаг.

Газар усны нэр судлал нь түүхийн салбар ухаануудаас түүхэн газар зүй, орон нутаг судлалтай холбоотой хөгжиж ирсэн бөгөөд нөгөө талаас газар зүйн шинжлэх ухааны газрын зураг зүйн салбар ухаантай холбогддог. Газар орны нэрийн үүслийг үгзүйн үүднээс судалдаг учраас хэл шинжлэлтэй ч мөн холбоотой. Тиймээс газар усны нэр судлал нь газар зүй, хэл шинжлэл, түүхийн ухааны уулзвар зааг дээр суурилан хөгждөг юм. Газар нутаг оршихуйн үндэс тул түүхэн газар усны нэр нь тухайн ард түмний газар нутагтаа эзэн болж оршин тогтнох үндсийг түүхийн үүднээс баталгаажуулж, тухайн ард түмэн ямар хэлний бүтцэд хамаардгийг тогтоох, эзэмшиж байсан газар нутаг, хил хязгаарыг нарийвчлан тогтоож өгдөг. Энэ салбар ухаан нь аливаа улс үндэстнийг он цагийн хувьд хэдийд шилжих хөдөлгөөн хийж, суурьшсан болоод нүүдэллэсэн тухай тодорхой мэдэх боломжийг бүрдүүлж өгдөг.

Газар усны нэрсийг тивүүд, бүс нутаг, улс гүрэн гэдэг орон зайн хэмжээсээр судалдаг. Гэхдээ түүхийн шинжлэх ухаантай холбогдож байгаагийн хувьд газар усны нэрийг орон зайн хэмжээст багтааж, түүхийн он дарааллаар түүхэн үйл явцтай холбон хэрхэн өөрчлөгдөж байгааг тодорхойлж өгдөг. Тухайлбал, Европ дахины дундад зууны үед газрын эздийн нэртэй холбоотой нэр томъёо ихэссэн бол газарзүйн их нээлтээс хойш газар усны нэрийн нөөц ихээхэн баяжсан.

Газар усны нэрийн бүтэц түүхэн үүднээс янз бүрээр бүрэлдэн тогтдог байна. Тухайлбал, Орост газар усны нэрийн үндсийг гол мөрний нэр бүрдүүлсэн байдаг². Эдгээр нэрс засаг захиргааны нэгжид хамаарах түүхэн хуваарилалтанд өөрчлөгдөхгүйгээр хадгалагдсаар байгаа юм. Мөн түүхийн урт удаан хугацааны туршид анх оноогдсон нэр олонтоо өөрчлөгдөж байсан тохиолдол байдаг. Жишээ нь: Солонгосын Пхеньян хотын нэр 30 гаруй янзаар өөрчлөгдөн тэмдэглэгдсэн байна.

Энэ нь хотжилт, хүн амын өсөлт, шилжилт суурьшилт, нийгэм эдийн засгийн хөгжлийг тодорхойлоход нөлөө үзүүлдэг. Улс үндэстэн мөхөхөд газар усны нэр нь үлддэг учраас түүхэн газар усны нэрийг түүх, хэл шинжлэлийн үүднээс тайлбарлан угсаатны зүйн онцлог, нутаг дэвсгэр, хил хязгаарын хэмжээг тодорхойлон гаргаж болно. Газар усны нэрийг зөв тогтоох нь газрын зургийг зөв үйлдэхэд ч чухал үүрэгтэй байдаг. Газар усны нэр судлалд нэгдүгээрт, эрхэлж буй аж ахуй, оршин амьдарч байсан газар нутагтай нь холбогдуулж өгсөн нэр; хоёрдугаарт, хэний эзэмшилд байгаагаар нь хүний нэрээр өгсөн нэр; гуравдугаарт, оюун санаа, ёс суртахууны талтай холбогдуулж өгсөн нэр;

¹ Топономика востока. Исследования и материалы. М., 1969. стр-28

² Е.М.Поспелов. Историко-топонимический словарь России. М., 2000.стр-9

дөрөвдүгээрт, колончлох үйл явцад хуучин газар усны нэрийг халж шинээр өгсөн нэр; тавдугаарт, нийгмийн өөрчлөлт, хувьсгал, бүтээн байгуулалтын үед өгсөн нэр хэмээн ангилан судалдаг.

Монгол орны газар усны нэрийг гол төлөв хэл шинжлэлийн үүднээс тайлбарлан судалсан байна. Хэл шинжлэл нь түүхэн газар усны нэрийг судлахдаа суурин орны нэр, уул овооны нэр, ус мөрний нэр, мод ургамлын нэр, амьтны нэрс гэсэн ангилалд багтаан судалдаг. Манай хэл шинжээч эрдэмтэн судлаачид энэ зарчимд түшиглэн судалгаа хийсэн байна. Хэл шинжээчид болоод түүхч, газар зүйчдээс Х.Пэрлээ "Нууц товчоонд гардаг зарим нэрийг хайж олсон нь", О.Пүрэв "Монгол ардын хувьсгалын түүхэнд холбогдох нутаг газар усны нэрийн товч тайлбар толь", "Д.Сүхбаатарын үйл амьдралд холбогдох нутгаар", Ч.Догсүрэн "Монгол нэр томъёо оноох, томилох, жигдлэх асуудал", З.Төмөрцэрэн "Монгол хэлний зарим төлөөний үгний тухай", Ц.Шагдарсүрэн "Монголчуудын үсэг бичгийн товчоон", С.Жамсран "Ардын хувьсгалын өлгий нутгийн түүх дурсгалын газрууд", О.Сүхбаатар "Монголын газар усны нэрийн домог", Ш.Шагдар "Монголын газарзүйн товч толь", "Монгол орноор жуулчлах зуун зам", Ж.Бямба "Домгийн мөрөөр", Ц.Лувсанцэрэн "Зуун нэрийн цомог" зэрэг бүтээлийг туурвижээ. Эдгээр бүтээлүүдэд Монгол орны түүхэн газар усны нэрсийг гол төлөв хэл шинжлэлийн үүднээс тайлбарласан. Харин түүхчдийн бүтээлүүдэд холбогдох газар усны нэрийг түүхэн үйл явдалтай холбогдуулан тайлбарлахдаа газарзүйн байрлалыг олж тогтоохыг хичээсэн байдаг. Орон нутаг дахь газар усны нэрийг сонирхон судлагчдаас Дорноговийн М.Чулуун, Завханы А.Сэлээд, Говь-Алтайн Г.Цэрэндаш нар тухайн газрын нэрийг түүхэн домог зүйн үүднээс тайлбарлах оролдлогыг хийж байна. Нөгөө талаас намтар судлал болон орон нутаг судлаачдын зарим нэг бүтээлүүдэд түүхэн газар усны нэрсийг тайлбарласан байдаг. Түүхч Н.Ишжамц "Хутаг уулын хошуу Хөвсгөл сумын түүх" бүтээлдээ өөрийн төрөлх газар усны нэрийг түүхийн олон үед яаж өөрчлөгдөж байсныг тэмдэглэсэн нь түүхэн газар усны нэр судлалын судалгааны арга зүйд дөхөж очсоныг анхаарууштай. Уг бүтээлд Дорноговийн Хөвсгөл сумыг Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошуу, Хутаг уулын хошууны Гуа, Жавхлант сумд Хөвсгөл уулын багт хамаарч байсныг тогтоожээ.

Түүхэн газар усны нэрийг "Монголын нууц товчооноос" түүхч Х.Пэрлээ "Нууц товчоонд гардаг зарим нэрийг хайж олсон нь" бүтээлээрээ анх удаа тайлбарлах оролдлого хийжээ. Уг бүтээлд "Монголын нууц товчоо"-нд гардаг газар усны зарим нэрийг тусгайлан оршин буй байршлаар нь газарзүйн уртраг өргөргийн хэмжээсээр гаргажээ. Жишээ нь "Монголын нууц товчоо" зохиолд 25 удаа тэмдэглэгдсэн Бурхан Халдун уулыг 109-р уртраг, 49-р өргөрөгт одоогийн Их Хэнтий, Бага Хэнтий хоёрын хооронд Хэнтийн гол нуруунд оролцсон уулсыг ерөнхийд нь Бурхан Халдун уул хэмээн тайлбарлажээ³. Судлаач О.Пүрэв өөрийн бүтээлдээ хувьсгалын түүхэнд холбогдох газар усны нэрийг тогтоохдоо гол төлөв оршин буй байрлалаар нь түүхэн үйл явцад хэрхэн холбогдож байгаагаар тайлбар хийжээ.Түүний судалсан 1300 гаруй нэрийн 800 шахам нь түүхэнд холбогдах жинхэнэ нэр байхад 500 нэр нь хувилбар буюу ташаа тэмдэглэгдсэн байна.

Газарзүйч Ш.Шагдар "Монголын газарзүйн товч толь" бүтээлдээ 8000 нэрийг гол төлөв оршин буй байрлалаар нь тогтоон тэмдэглэсэн байна. Жишээ нь түүний бүтээлд тэмдэглэгдсэн Зүүнхарааг энэ нь төмөр замын өртөө хэмээн тайлбарлажээ.

³ Х.Пэрлээ. "Нууц товчоонд гардаг газар усны нэрийг хайж олсон нь". УБ., 1957. тал-36

Төв аймгийн Баянцагаан сумын төв нь 23 км зайтай Зогсоол уул юм. Хуучин Зогсоол жаргалант уулын хошуу гэж нэрлэж байсны Зогсоол уулыг сонгон авчээ. Баянцагаан сумын төв Хүйсийн худаг нэртэй газар байдаг. Гэтэл газрын зурагт тэмдэглэхдээ Хүйс гэдэг нэр нь зохимжгүй тул Зогсоол уулаар нэрлэхээр болжээ.

Газар усны нэрийг тогтоож, газрын зураг үйлдэх энэхүү ажилд аймаг, сум бүрээс газарчинг сонгон ажиллуулсан байна. Тухайлбал, Дорноговь аймгийн Айраг сумын газар усны нэрийг 1980 онд газарчин Жамбал, Балжид, Ламхүү, Базарсад нар тодруулж, 1984 онд Улсын геодези зураг зүйн газарт тухайн сумын газрын зургийг үйлдвэрлэсэн баримт байдаг байна. Ийнхүү монгол орны бүх сумдын газрын нэрийг улсын хэмжээнд тогтоож газрын зураг үйлдэх ажлыг хийжээ.

Монгол улсын хэмжээнд нийтдээ 350 мянган газар усны нэр байдаг. Жишээ нь: Улсын газар нутгийн байнгын комиссын тогтоолоор Дорноговь аймгийн 13 суманд 11147 нэрийг баталсан бол Архангай аймгийн 17 сумын 16896 нэрийг баталж зургийг үйлдсэн байна⁴. Дээрх 2 аймгийн газрын нэрийг үзвэл Дорноговь аймгийн нутагт нийт газрын 80%-г жаргалант толгой, модон толгой, ухаа толгой, овоот толгой, оорцог толгой, цахиур толгой, өндөр толгой г.м нэрс зонхилдог. Тэгвэл Архангай аймгийн газрын нэрийн 70-80%-г чулуут уул, хүрэмт уул, хөх уул, баян улаан уул, сонгинот уул, хадат уул, бичигт уул, цагаан уул, мөст уул г.м нэр зонхилж байна. Энэ нь Монгол орны газрын нэр физик газарзүйн бүсчлэлтэй холбогдон нэрлэгддэгийн илэрхийлэл юм.

Цаашид газар нутгийн байнгын комиссоор баталгаажсан нэрийг түүхэн газар усны нэр судлалын судалгааны аргазүйд түшиглэн нутаг дэвсгэрийн хуваарилалтын түүхэн уламжлалд багтааж тодруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Одоогийн засаг захиргааны хуваарилалтын нэрийг түүхэн үүднээс мөшгиж түүхэн газарзүйн судалгааны эх сурвалжид түшиглэж уул усны нэрс, түүхэнд холбогдох газар усны нэрийг багтаан түүхч, хэл шинжээчид болоод газарзүйчдийн хийсэн судалгааны ажилтай уялдуулан үечилж тодотгож өгөх нь зүйтэй болов уу.

⁴ Монгол улсын геодези зураг зүйн газар. Газрын зургийн эмхтгэл. 1984. хавсралт №1